



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 803

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолын нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын харьяа хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 91,920,432.00 (ерэн нэгэн сая есөн зуун хорин мянга дөрвөн зуун гучин хоёр) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар болон харьяа хэлтсийн дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003048

32-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
2023 дугаар тогтоолын хавсралт

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ХАРЬЯА ХЭЛТСИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Дорнод аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс				
1	Делика микро улсын дугаар 84-01 ДОР, арлын дугаар PD8W0200796	1998/2013	20,000,000.00	3,500,000.00
Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс				
2	УАЗ Пургон маркийн суудлын автомашин, улсын дугаар 08-68 ГАА, арлын дугаар 374100B0450773	2011/2011	20,600,000.00	3,500,000.00
Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс				
3	УАЗ-220692 маркийн Пургон автомашин, улсын дугаар 79-64 ХӨВ, арлын дугаар 374100B0466724	2011/2012	22,000,000.00	3,500,000.00
4	Ландкрузер-100 улсын дугаар 18-92 ХӨҮ, арлын дугаар JTEHJ09J525051197	2002/2003	29,320,432.00	17,000,000.00
Нийт дүн			91,920,432.00	27,500,000.00
			(ерэн нэгэн сая есөн зуун хорин мянга дөрвөн зуун гучин хоёр төгрөг)	(хорин долоон сая таван зуун мянга)